

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
77 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Эдийн засаг, хөгжлийн яам

Нэгжийн нэр:

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газар

Албан тушаалын нэр:

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Эрхэлсэн түшмэл, ТЗ-2

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт болон технологи, инновацийн шилжилт, салбарын оюуны өмчийг хөгжүүлэх, мөн үндэсний болон шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн чиглэлээр батлагдсан урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн төсөл, холбогдох бусад эрхзүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, Сайд, Төрийн нарийн бичгийн даргыг мэдээллээр хангах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт болон технологи, инновацийн шилжилт, салбарын оюуны өмчийг хөгжүүлэх, үндэсний болон шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн талаар баримтлах хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, хууль тогтоомжийн төсөл, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг төлөвлөх, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний бодлогын шинжилгээ хийх, санал боловсруулах, хуулийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд шаардагдах дүрэм, журам болон эрхзүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 2.Эрдэм шинжилгээний байгууллагын өрсөлдөх чадварыг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, салбарын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн үр ашигтай тогтолцоог нэвтрүүлэх;
- 3.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт үр дүнд суурилсан шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын үйл ажиллагааг цахимжуулах, төрийн цахим нэгдсэн системд нийцүүлэх, технологийн түвшний үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд мэдээллээр үйлчлэх, инновацын үйл ажиллагаа эрхлэгчид, гарааны компанийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх;
- 4.Шинжлэх ухаан, технологийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого, боловсруулах, шинжлэх ухаан, технологи, инновацын судалгаа хөгжүүлэлтийн мэдээллийн санг хөгжүүлэх, удирдлагаар хангах, шинжлэх ухаан, инновац, технологийн ололт, амжилт болон монгол судлалыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах;
- 5.Нэгжийн албан хаагчдын үйл ажиллагааг удирдлага, манлайллаар хангах, үнэлгээ өгөх, төрийн албан хаагчийн нийтлэг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх;
- 6.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт болон технологи, инновацийн шилжилт, салбарын оюуны өмчийг хөгжүүлэх, үндэсний болон шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн талаар баримтлах хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, хууль тогтоомжийн төсөл, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг төлөвлөх, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний бодлогын шинжилгээ хийх, санал боловсруулах,	Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, технологийн шилжилт, оюуны өмчийг хөгжүүлэх эрхзүйн зохицуулалт бүрдсэн байна. Үндэсний болон шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн талаар баримтлах хөгжлийн дунд, урт хугацааны бодлого, хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Т



хуулийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах,		
2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн болон Технологи дамжуулах, Оюуны өмчийн тухай хууль тогтоомж, холбогдох бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдамжаар хангах;	Хэрэгжилтийг төрийн бодлого, хөтөлбөртэй уялдуулсан байна.	Г, Х
3.Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил, арга зүй удирдлагаар хангах;	Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
4.Шинжлэх ухаан, технологийн салбарын оюуны өмчийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;	Оюуны өмчийн бодлогын хэрэгжилтийг хангасан байна.	Ш, Г, Х, Т
5.Шинжлэх ухаан, технологи-аж үйлдвэрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх.	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон үндэсний технологийг нэвтрүүлэх чиглэлээр шинжлэх ухаан-аж үйлдвэрийн хамтын ажиллагаа эрчимжсэн байна.	Ш, Г, Х, Т
6.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт мөрдөгдөх хууль, журам, дүрэм, стандарт норм нормативыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;	Батлагдсан хууль эрхзүйн баримт бичиг, журам дүрэм, стандарт, норм нормативыг мөрдүүлсэн байна.	Г, Х
7.Салбарын үйл ажиллагаанд төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, хувийн судалгаа, хөгжүүлэлтийн байгууллагыг дэмжих, үйл ажиллагааны таатай орчин	Таатай орчин бүрдүүлж төр-хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд хүргэсэн байна.	Г, Х




	бүрдүүлэх;		
	8.Монгол судлалын хөгжлийн бодлого болон шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;	Түгээн дэлгэрүүлэх ажлын зохион байгуулалтыг тогтмолжуулсан байна.	Г, Х
	9.Шинжлэх ухааны ололт, амжилтыг түгээн дэлгэрүүлэх;	Бодлогыг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	10.Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагаас шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;	Арга зүйн нэгдсэн удирдлагаар хангасан байна.	Г, Х
	11.Шинжлэх ухааны салбарын дотоод, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээ авах.	Шинжлэх ухааны дотоод болон гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, технологийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал төлөвлөн боловсруулах, хэрэгжилтийг хангах;	Эрдэм шинжилгээний байгууллагуудын чадавх сайжирч, олон улсын жишигт хүрсэн байна.	Г, Х, Т
	2.Шинжлэх ухааны парк байгуулах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллах;	Шинжлэх ухааны парк байгуулагдаж, үйл ажиллагаа тогтмолжсон байна.	Г, Х, Т
	3.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, хөгжүүлэлтийн ажлын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж уялдааг хангах;	Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн, улс орны хөгжлийн стратеги, бодлоготой уялдуулан гүйцэтгэж, чанарын ахиц гарсан байна.	Ш, Г, Х, Т



	4.Шинжлэх ухаан, технологийн төслийн сонгон шалгаруулалт, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;	Төслийн шалгаруулалт боловсронгуй болсон байна.	Ш, Г, Х, Т
	5.Салбарын хатуу болон зөөлөн дэд бүтцийг бэхжүүлэх, уялдаа холбоог сайжруулах, дагнасан болон салбар дундын судалгаа, төвүүдийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах;	Салбарын судалгааны дэд бүтэц сайжирч судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр өгөөж дээшилсэн байна.	Г, Х, Т
	6.Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний боловсруулалтын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Санхүүжилтийн үр ашиг дээшилсэн байна.	Г, Х, Т
	7.Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн менежмент, үйл ажиллагааны шинэчлэлийг удирдлага зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих;	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн менежмент, үйл ажиллагаа, зохион байгуулалт сайжирсан байна.	Г, Х, Т
	8.Шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, судалгаа хөгжүүлэлтийн үндэсний статистикийг гаргах;	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын дэлхийн шинжлэх ухааны болон улс орны эдийн засаг нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр нэмэгдсэн байна.	Г, Х, Т
	9.Залуу эрдэмтэн судлаачдыг дэмжих бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг ханган ажиллах, түгээн дэлгэрүүлэх;	Залуу эрдэмтэн судлаачийн судалгааны чадавх бэхэжсэн байна.	Г, Х, Т
	10.Төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудтай эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх.	Хамтын ажиллагаа эрчимжсэн байна.	Г, Х, Т
3 дугаар зорилтын	1.Инновацийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, технологи хөгжүүлэлт,	Холбогдох тэргүүлэх тодорхойлох, бодлого, чиглэлийг төлөвлөх,	Г, Ш



хүрээнд	нутагшуулалт, инновацыг дэмжих, урамшуулах, энэ чиглэлд судалгаа хөгжүүлэлтийг эрчимжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.	хэрэгжилтийг удирдлагаар ханган ажилласан байна.	
	2.Үр дүнд суурилсан инновац, технологийн судалгаа, грант, туршилт зүгшрүүлэлтийн төслийг тэргүүлэх чиглэл, цөм технологийн хүрээнд сонгон шалгаруулах, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалт, мэргэжлийн арга зүйн зохицуулалтаар хангах;	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар, үр өгөөж, хүртээмж дээшилсэн байна.	Ш, Г, Х, Т
	3.Инновац, технологийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүн, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулах, технологи дамжуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, дэмжлэг үзүүлэх;	Инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, өрсөлдөх чадвар бэхэжсэн байна.	Ш, Г, Х, Т
	4.Гарааны компанийг бүртгэх, үйл ажиллагааг дэмжих, гарааны бизнесийг бойжуулахад чиглэсэн төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүй, үйл ажиллагааны нэгдсэн удирдлагаар хангах,	Инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээний тоо нэмэгдэж, өрсөлдөх чадвар бэхэжсэн байна.	Ш, Г, Х, Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх, хатуу болон зөөлөн дэд бүтцийг бэхжүүлэх бодлого, хөтөлбөр, зураглалыг боловсруулах, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах;	Инновацийн дэд бүтэц бэхэжсэн байна.	Г, Х, Т
	2.Шинжлэх ухааны паркийн эрх зүйн зохицуулалт, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог оновчтой тогтоох, хэрэгжилт, зохицуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах,	Шинжлэх ухааны парк байгуулах нөхцөл бүрдэж, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа тогтворжсон	Г, Х, Т




	хяналт тавьж ажиллах;	байна.	
	3.Инновацийн үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалтын механизмыг олон эх үүсвэртэй, боловсронгуй болгох, тогтвортой байдлыг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах;	Санхүүжилт, хөрөнгө оруулалтын тогтвортой механизм бүрдэж, үр ашиг дээшилсэн байна.	Г, Х, Т
	4.Шинжлэх ухаан, инновац, технологи, судалгаа хөгжүүлэлтийн нэгдсэн платформ бүрдүүлэх, хөгжүүлэх, инновацын ололт, амжилт болон Монгол судлалыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;	Судалгаа хөгжүүлэлт, инновацын нэгдсэн платформ бий болсон байна. Шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг олон нийтэд сурталчлан таниулна. Монгол судлалыг олон улсад сурталчлах, хөгжүүлэх ажлыг удирдлага зохицуулалтаар ханган ажилласан байна.	Г, Х, Т
5 дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэгтэй холбоотой хууль, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах, удирдлагаар хангах;	Үр дүнтэй хэрэгжсэн байна.	Г, Т
	2.Мэргэжилтнүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хариуцсан ажлын чиглэлээр дэмжлэг, туслалцаа үзүүлэх;	Үр дүнтэй хэрэгжсэн байна.	Г, Т
	3.Мэдээлэл, тайлагналыг нэгтгэн хариуцаж бусад нэгж, холбогдох байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах;	Үр дүнтэй хэрэгжсэн байна.	Г, Ш, Т
	4.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд урт, богино, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулан мөрдөх;	Баталж, мөрдсөн байна.	Г, Ш
	5.Захиргааны акт болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг олгогдсон эрхийн	Үр дүнтэй хэрэгжсэн байна.	Г




	хүрээнд боловсруулах, батлуулах, хувийн хэрэг бүрдүүлэх;		
	6.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих;	Баримталсан байна.	Г
	7.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журмын хэм хэмжээг мөрдөх;	Мөрдсөн байна.	Г
	8.Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;	Идэвхтэй оролцсон байна.	Г
	9.Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих	Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлсэн байна.	Г
	10.Эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч, шаардлагатай мэдээллээр хангах.	Үр дүнтэй хэрэгжсэн байна.	Г, Т
	11.Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг маягтын дагуу мэдээлэх	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв, хугацаанд нь гаргасан байна.	Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Х, Г
	2.Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Г
	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг "Яамны хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г



	архивын нэгж болгон хадгалуулах;		
	4.Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх.	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Т, Г, Х
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- Байгалийн шинжлэх ухаан /0532/; - эрхзүй /0421/; - менежмент ба удирдахуй /0413/; - инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл /0713/; - багш, мэргэжлийн /0114/; - бизнес удирдлага, эрх зүйд хамаарах салбар дундын чиглэл /0488/; - нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүлзүй /0321/.		
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх		
Туршлага	- Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх; - хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах; - нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; - санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; - салбарын эрсдэлийн удирдлагын бодлогод суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах; - шинжлэх ухааны салбарын бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих.	
	Дүн шинжилгээ хийх	- шинжлэх ухааны салбарын аливаа асуудлыг хуулийн хүрээнд үнэн бодит мэдээлэлд тулгуурлан судалж, шийдлийн олон хувилбарыг боловсруулах, хууль, эрх зүйн судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах; - бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан, харилцааны соёлыг эрхэмлэх;	



		- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - бүтээлч, санаачилгатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бусад.
	Манлайлах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгож ажиллах; - зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа хамт олондоо үлгэр дуурайл үзүүлэх; - ажлын шинэ арга барилыг нэвтрүүлж, хөгжүүлэх, бүтээлч, санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо таниулах, ойлгуулах, хэрэгжүүлэх; - нэгжийн зорилтыг тодорхойлохдоо хамт олны оролцоог хангах, санал авах, тусгах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд таниулах; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - жендерийн тэгш байдлыг хангах; - судалгаа хөгжүүлэлтийн менежментийн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан бол давуу тал болно.
IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		



Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Төрийн нарийн бичгийн дарга

Албан тушаалд шууд харьяалан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- хэлтсийн дарга - 2
- ахлах шинжээч - 1
- шинжээч - 3
- ахлах мэргэжилтэн - 2

Нийт: 8

Бусад харилцах субъект

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн холбогдох албан тушаалтан;
- Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын холбогдох албан тушаалтан;
- Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

1732851 6806238 9022010236

2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

Дугаар:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2025.03.24

Дугаар: А/79
(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА (И.БАТХҮҮ)

2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр